



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД
УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ
АСУУЛГА

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatrural@parliament.mn
<http://www.parliament.mn>

2020. 04. 22 № 06

Асуулга тавих тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.13, 33 дугаар зүйлийн 33.1.2 дахь заалтад тус тус заасны дагуу Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайд Ухнаагийн Хүрэлсүх Танд хандан дараах асуултгыг тавьж байна.

Дэлхийн 205 улс, нутаг дэвсгэрт дэгдсэн коронавируст (COVID-19) халдвартын цар тахалд манай улсыг "Эрсдэл өндөртэй" улс гэж Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас зарласантай холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх шийдвэр гаргаж, шат дараатай арга хэмжээ авч ажилласны үр дүнд халдвартыг эх орондоо тодорхой хугацаанд оруулахгүй барьж чадсаныг сайшааж байна.

Манай улсад 2020 оны 03 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн өнөөдрийн байдлаар нийт 14 тохиолдол бүртгэгдсэн нь бүгд гадаад улсаас зөөвөрлөгдөн орж ирсэн бөгөөд эхнээсээ эдгэрч байгаа боловч цаашид халдвартын тархалтын эрсдэл өндөр хэвээр байгаатай холбогдуулан нийгэм, эдийн засагт сэргээр нэлөөлж буй хор уршигийг үнэлэн тооцоолох, ард иргэдийн амьжиригааг дээшлүүлэх, нийгэм, эдийн засгийн тогтвортой байдлыг сэргээх, гамшгийн бэлэн байдлыг сайжруулах чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаар доор дурдсан мэдээллийг ирүүлнэ үү:

1.Хүн амын эрүүл мэндийн аюулгүй байдлыг хангах эмнэлгийн оношилгоо, үйлчилгээ, эм, эмнэлгийн болон хамгааллын хэрэгсэл, тоног төхөөрөмж, ажиллах хүчиний нөөц хангамж, түүний хуваарилалт, төлөвлөгөөний талаар;

2.Цар тахлаас урьдчилан сэргийлэх, тандалт судалгаа, шинжилгээ, нийгмийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллагуудын авч хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, бэлтгэл бэлэн байдал, хариу арга хэмжээ, дайчиллагааны төлөвлөгөөний талаар;

3.Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд оролцож буй төрийн албан хаагчдын гэр бүлийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд төрөөс үзүүлж буй тусlamж, дэмжлэг, авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөөгөөний талаар;

4.Халдвартын голомт бүхий гадаад улс орноос Монгол Улсад ирсэн иргэдийг тусгаарлан ажиглалт хийх, эмчлэх байрны нөхцөл байдал, хоол, хүнсний үйлчилгээ, халдвартгүйжүүлэлт, аюулгүй байдал, эмнэлгийн болон ахуйн хог хаягдлын устгалыг хийх талаар авч хэрэгжүүлж буй буй арга хэмжээ, төлөвлөгөөний талаар;

2020000023

5.Халдвартын голомт бүхий гадаад улс орноос монгол иргэдийг эх орондоо татан авчрах судалгаа, тооцоо, төлөвлөгөөний талаар;

6.Коронавируст (COVID-19) халдвартын тархалтын үед Засгийн газраас авч хэрэгжүүлж буй эдийн засгийн бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэрийг хэрхэн бүрдүүлэх, зарцуулах төлөвлөгөөний талаар;

7.Коронавируст (COVID-19) халдвартын цар тахлаас урьдчилан сэргийлэх, хамгаалах үйлсэд ард иргэд, гадаад, дотоодын аж ахуйн нэгж, бусад улс орны Засгийн газар болон олон улсын байгууллагуудаас үзүүлж буй санхүүжилт, хандив тусламж, түүний зарцуулалт, хуваарилалтын талаар;

8.Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавар гарч байгааг тооцоолж, эдийн засгийн эргэлтийг сэргээх, аж ахуйн нэгж, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг дэмжих зорилго бүхий "Хямралын эсрэг" тусгай сан бүрдүүлэх тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгыг хэрэгжүүлэх талаар;

9.Үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан шаардлагатай хууль, тогтоомжийг боловсронгуй болгох хуулийн төслийн талаар;

10.Коронавируст (COVID-19) халдвартын эсрэг вакцин, эмчилгээ, сувиллын талаар дэлхийн улс орнуудад хийгдэж байгаа туршилт, туршлага, нөхцөл байдлын талаар зэрэг болно.

Асуулгын хариуг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.3 дахь хэсэгт заасан хугацаанд ирүүлж, Улсын Их Хурлын чуулганы 2020 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар сонсгохыг Танаас хүсье.

Хүндэтгэсэн,

Улсын Их Хурлын гишүүн:



Д.ОЮУНХОРЛОГ

С.БЯМБАЦОГТ

М.ОЮУНЧИМЭГ

Я.САНЖМЯТАВ

Л.ЭНХ-АМГАЛАН

Д.ЭРДЭНЭБАТ

2020000023